

Мэдээллийн Хуудас

МОНГОЛД ЗЭС ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТУХАЙ

ТАНИЛЦУУЛГА

Зэс болон бусад эцсийн бүтээгдэхүүн газраас ухаж гарган боловсруулах нь нарийн төвөгтэй ажил юм. Хэд хэдэн үе шат, олон төрлийн механик болон химийн дамжлагаар ахуйн хэрэглээ, машин техник зэрэгт ашиглах эцсийн бүтээгдэхүүн бий болно.

Олборлолтын дараа “хүдэр” буюу буталсан хад чулууг нунтаглаж, баяжуулан, хайлуулан дахин цэвэршүүлдэг. Үе шат бүр дээр хольцыг ялгаж, зэсийн агууламжийг нэмэгдүүлнэ.

Оюу Толгой уурхайд зэсийн баяжмал үйлдвэрлэж, 30 хүртэлх хувийн агууламжтай нунтгийг хэрэглэгчдэд нийлүүлдэг.

ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИ ЯАГААД ЗЭС, АЛТЫГ ХАЙЛУУЛЖ ЦЭВЭРШҮҮЛДЭГГҮЙ ВЭ?

Дэлхийн ихэнх компаниуд эцсийн бүтээгдэхүүн зардаггүй, харин бусдаар боловсруулалт хийлгэх бүтээгдэхүүнээ өндөр үнээр борлуулдаг. Оюу Толгой компанийн хувьд ч адилхан.

Оюу Толгой бол уул уурхайн компани, зэс хайлуулах, дахин цэвэршүүлэх үйлдвэр биш. Бид эрдэс баялагаа олборлож, зэсийн баяжмалаа дэлхийн зах зээлд гарган компани болон оролцогч талууддаа ашиг тус хурдан авчрах зорилготой юм.

ИРЭЭДҮЙД ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ УУ?

Оюу Толгой компанийн дараагийн ээлжинд хийх ажлууд нь далд уурхай болон уурхайг эрчим хүчээр хангах цахилгаан станц барих зэрэг бүтээн байгуулалтууд байна.

Гэхдээ Оюу Толгой компани Монголд хайлуулах үйлдвэр барих эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад Монголын Засгийн газарт туслана. Энэ бол бидний Хөрөнгө Оруулалтын Гэрээний дагуу хүлээсэн үүрэг юм.

ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ

- Хайлуулах үйлдвэр хөрөнгө оруулалт их шаарддаг
- Эдийн засгийн хувьд үр ашигтай байхын тулд зэсийн уурхайд ойр байршуулдаг
- Хайлуулах үйлдвэр эрчим хүч их хэрэглэдэг
- Хайлуулах үйлдвэр хүрээлэн буй орчинд нөлөө үзүүлдэг

МОНГОЛД ЗЭС ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГАА

Оюу Толгой компани Монголд хайлуулах үйлдвэр байгуулах эдийн засгийн үндэслэлийг судлахад Монголын Засгийн газарт туслах болно. Үйлдвэрлэлээ эхлүүлснээс хойш гурван жилийн дотор, Засгийн газраас бичгээр үйлдсэн хүсэлт хүлээн авсан

тохиолдолд, Оюу Толгой компани Монголд зэс хайлуулах үйлдвэр барьж ажиллуулах эдийн засгийн үндэслэлийн судалгааны тайланг бэлтгэн боловсруулна.

2012 онд, Оюу Толгой компани Монгол улсын Засгийн газартай хамтран зэс хайлуулах үйлдвэрийн эдийн засгийн үндэслэлийг судлах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг

боловсруулсан. Оюу Толгой компани Монгол улсын Засгийн газартай хамтарч энэ санамж бичгийг эцэслэн зэс хайлуулах үйлдвэрийн эдийн засгийн үндэслэлийн судалгааг хэрхэн оновчтой хийх талаар шийдвэр гаргахад бэлэн байна. Засгийн газрын хувьд энэ бол томоохон шийдвэр болох бөгөөд Оюу Толгой компани дэмжлэг үзүүлэхэд бэлэн байна.

ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИ ХАЙЛУУЛАХ ҮЙЛДВЭР БАРИХ БОЛ ХЭДИЙ ХЭМЖЭЭНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Оюу Толгой компани өөрийн хайлуулах үйлдвэр барих бол, нэмэлт хэд хэдэн тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Энэ нь ашиг хүртэх болон хувь нийлүүлэгчдэд, түүнчлэн Монголын Засгийн газарт ногдол ашиг төлж эхлэх хугацааг хойшлуулахад хүргэнэ. Хайлуулах үйлдвэр ажиллуулах зардал маш өндөр.


Оюу Толгой компанийн хувьд түргэн хугацаанд ашигтай ажиллах зам бол зэсийн баяжмалаа дэлхийн зах зээлийн үнээр нийлүүлэхэд оршино.

Мэдээллийн Хуудас ЗЭСИЙГ ХЭРХЭН ҮЙЛДВЭРЛЭДЭГ ВЭ?

01 Ордоос хүдрээ олборлоно. Хүдэр нь зэс болон бусад металл, чулуулаг зэргийг агуулдаг.



02 Оюу Толгойн баяжуулах үйлдвэр нь олон тоног төхөөрөмжөөс бүрддэг. Эдгээр нь хүдрийг буталж нунтаглан, механик болон химийн дамжлагаар 30 хүртэлх хувийн зэсийн агууламжтай баяжмал үйлдвэрлэнэ.




03 Баяжмалаа хэрэглэгчдэд нийлүүлж, Засгийн газарт татвар, төлбөр төлнө.



04 Хайлуулах үйлдвэрт баяжмалыг 1000 градусаас дээш температурт халаадаг. Үүний үр дүнд 30-70 хувийн зэсийн агууламжтай бодис үүснэ.



05 Дараа нь зэсийг борлуулж, дахин цэвэршүүлэх үйлдвэрлүү явуулдаг. Энд хэд хэдэн нарийн процессуудаар дамжуулан бараг цэвэр зэс бий болгодог.



06 Үүний дараа цэвэр зэс борлуулж, барилга болон аж үйлдвэрт ашиглана.

